



## Монголын Бизнесийн Зөвлөл

Утас/Факс: 976-11-332345  
И-мэйл: [info@bcmongolia.org](mailto:info@bcmongolia.org)  
[www.bcmongolia.org](http://www.bcmongolia.org)

Нийгэмд улам бүр байр сууриа бататган, нэр хүнд нь өсөж, үйл ажиллагаа нь өргөжин тэлж байгаа Монголын Бизнесийн Зөвлөлд гишүүнээр элсэж, нэгдэхийг сонирхож байгаа танд талархал илэрхийлье.

Улс орны эдийн засгийн хөгжлийг сааруулж байгаа хүчин зүйлсийг арилгахад нэмэр тус болох, гишүүдийн болоод ерөнхий бизнесийн харилцаанд чухлаар тавигдаж байгаа асуудлын эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор төр засгийн байгууллагуудтай санал солилцох талбар нь болж олон улсын стандарт бодлого, практикт үндэслэсэн санал зөвлөмжийг төр засгийн байгууллагад хүргэж монгол улсын худалдаа хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах үндсэн зорилготой байгуулагдсан байнгын ажиллагаатай энэхүү төрийн бүс байгууллагад өнөөдрийн байдлаар 140 орчим монголын болоод гадны хөрөнгө оруулалттай компаниуд, олон улсын байгууллагууд, элчин сайдын яамдууд болон монголд үйл ажиллагаа явуулахаар бэлтгэж байгуу буюу холбогдох асуудлаар сонирхон судалж байгаа дэлхийд нэр хүндтэй ING, Ocean Partners, PricewaterhouseCoopers зэрэг үндэстэн дамжсан олон улсын компаниуд нэгдсэнийг мэдэгдэхэд таатай байна.

Тус байгууллагын гишүүн болсноор Та:

Монголын Бизнесийн Зөвлөлөөс сар бүр зохион байгуулагддаг бүх гишүүдийн уулзалт арга хэмжээнд оролцож монголд үйл ажиллагаа явуулж байгаа томоохон хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдийн удирдах хүмүүстэй уулзан танилцаж ажил хэргийн харилцаагаа өргөжүүлэх бололцоотой.

Монголын Бизнесийн Зөвлөлөөс сар бүр зохион байгуулагддаг бүх гишүүдийн уулзалтын үеэр төр засгийн томоохон албан тушаалтан, тухайн арга хэмжээний илтгэгч нараас тодорхой асуулт, асуудлыг тавьж өөрийн хэрэгжүүлж байгаа бизнесийн салбарын дуу хоолой нь болох боломжтой.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа Дипломат төлөөлөгчийн газрууд, олон улсын байгууллагуудын тэргүүн нартай уулзан танилцах боломжтой.  
Монгол Улсад үйл ажиллагаа явуулахаар зэхэж байгуу хөрөнгө оруулагчдын талаар мэдээлэл авч, холбоо тогтоох боломж нөхцөл бий болно.

Монголын Бизнесийн Зөвлөлөөс зохион багуулах аливаа арга хэмжээ, сургалт, зөвлөлгөөний талаар мэдээлэл авч хөнгөлөлттэй нөхцлөөр оролцох боломжтой.

Монголын Бизнесийн Зөвлөлөөс 7 хоног бүр албан ёсны эх сурвалжаар бэлтгэдэг монгол орны эдийн засаг, улс төр, зах зээлийн талаар хамгийн сүүлийн үеийн англи хэл дээр илгээгдэх мэдээллийг ашиглан гадны түнш байгууллагуудтайгаа харилцах боломжтой зэрэг олон олон үр ашигтай нөхцлийг бид санал болгож байна.

Холбогдох асуудлаар 332345, 9906-6062 дугаарын утас, [serod@bcmongolia.org](mailto:serod@bcmongolia.org) и-мэйлээр надтай шууд харилцах буюу [www.bcmongolia.org](http://www.bcmongolia.org) вэб сайтаас дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.

ДЭД ЗАХИРАЛ

И.СЭР-ОД